



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№154 /368/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.30

Цаг үе, үйл явдал

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫХАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД АЖИЛЛАЖ БАЙНА



УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын гуравдугаарт "Зүүнбаян ханги чиглэлийн төмөр замын сүлжээг байгуулах

төсөл" багтаж бүтээн байгуулалтын ажил эхлээд байгаа юм. Үүнтэй зэрэгцэн Улаанбаатар Дархан чиглэлийн авто замын ажил мөн явагдаж буй. Эдгээр бүтээн байгуулалтын ажилд

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын алба хаагчид оролцож байна. Зам барилгын бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа алба хаагчдын замын хөдөлгөөнд оролцох үеийн аюулгүй байдал, осол зөрчилгүй ажиллах

нөхцөл бололцоог хангах зорилгоор Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны алба хаагчид хамтран үүрэг гүйцэтгэж байна.

Улаанбаатар-Дархан-Уул чиглэлийн автозамын шинэчлэлийн ажилд Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Дархан цэргийн хүрээний тээврийн хяналтын байцаагч ахлах дэслэгч О.Шинэбар, Арвайхээр цэргийн хүрээний тээврийн хяналтын байцаагч дэслэгч А.Ганзориг, Дорноговь аймаг Ханги-Мандал чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Зуунмод цэргийн хотхоны тээврийн хяналтын байцаагч дэслэгч Д.Баттулга, Даланзадгад цэргийн хүрээний тээврийн хяналтын байцаагч дэслэгч М.Батдорж нарын алба хаагчид тус тус ажиллаж байна.

**Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах мэргэжилтэн ахлах дэслэгч Д.Ганхуяг**

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	🌧️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.221	3.225
EUR 🇪🇺	3.241	3.255
CNY 🇨🇳	468	471
RUB 🇷🇺	49.80	50.20
JPY 🇯🇵	23.45	23.80
KRW 🇰🇷	2.38	2.40

### ЗУРХАЙ



2022.08.30 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ДӨРВӨН НОГООН ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эд мал баялаг төгөлдөр болно  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
06.07-19.39  
**Барилдлага:**  
Хүчин төгсөх  
**Шүтэн барилдлага:**  
САНСАР  
**Суудал:** Хий

## ЦОГЦОЛБОР ШАЛГАЛТЫН ЭРГЭН ТОЙРОНД..



### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 325 ДУГААР АНГИ

ЗХЖШ-ын төлөвлөгөөт цогцолбор шалгалтад 2022 оны 8 дугаар сарын 22-ноос 25-ны өдрүүдэд амжилттай хамрагдлаа.

Цогцолбор шалгалтаар тус ангийн бэлэн байдал, цэргийн алба, сургалт бэлтгэл зэргийг шалгаж үнэлэхээс гадна бие бүрэлдэхүүний алба хаах

орчин, ажил үүргээ гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямбад уламжлав.

Мөн шалгалтын төгсгөлд комиссын бүрэлдэхүүн болон ангийн удирдлага, тусгай салбарын захирагч нарын дунд нөхөрсөг "Гар бөмбөг"-ийн тэмцээнийг зохион байгуулжээ.

**АХМАД Н.МӨНХБААТАР**

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 016 ДУГААР НЭГТГЭЛ

ЗХЖШ-ын цогцолбор шалгалтын тактикийн хээрийн сургуульд амжилттай оролцож үүргээ амжилттай биелүүлэн хамт олноо манлайлсан Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байлдагч Н.Эрхбаяр, Т.Амармэнд "Онц буудагч", байлдагч М.Мөнхтөгөлдөр, Т.Сүхбат "Онц

сурлагатан", байлдагч Б.Хосбаяр "Тамирчин дайчин" тэмдгээр тус тус шагнажээ.

Шагналыг ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын хэлтсийн дарга, цогцолбор шалгалтын комиссын дарга хурандаа Д.Жигжидсүрэн, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр нар гардуулан өгч, баяр хүргэсэн юм.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 606,757,311

Эдгэрсэн

Нийт: 582,602,456

Нас барсан

Нийт: 6,490,391

# ДЭД ТҮРҮҮЧИЙН БЯЦХАН ХҮҮДЭЭ БИЧСЭН ЗАХИДАЛ



Цэргийн гавьяаны одонт, БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн I мотобуудлагын ротын I мотобуудлагын салааны II тасгийн захирагч, дэд түрүүч Цэрэнхандын Нандинболор хайрт хүү Н.Уужимтөрд захидал илгээснээ бидэнд ирүүллээ. “Сайн байна уу, миний хүү. Хичээлийн шинэ жил

эхлэх гээд миний алаг нүдэн хүү цэцэрлэгтээ орохоор хөөрч баярлаад гүйж явна уу. Цэцэрлэг ямар гоё билээ, Оюухай эмээгээ дагаж уйлахгүй үлдэхээ мэдэж байгаа биз дээ, миний хүү. Үеийн олон жаалхан хүүхдүүдтэй тоглоод гоё доо тэ. Аав нь сайн. Аав нь эр цэргийн албанд ирээд олон зүйлийг ойлгож, мэдэрч, бахархаж явна. Эх оронд эр цэргүүд ямар үнэ цэнтэйг, хувийн

зохион байгуулалт, эмх цэгц ажил урагшлахад ямар дөхөм байдгийг, олон аавын хөвгүүдтэй нөхөрлөх нь ямар сайхан дурсамж үлдээдгийг, цэргийн алба нь юуны учир эрчүүдээ сургаж бэлтгэдгийг, сургагдсан эрчүүдэд ямар бахархал, омогшил төрдгийг аав нь бие, сэтгэлээрээ мэдэрч байна. Үнэхээр сайхан алба юм аа. Аав нь цэргийн албанд ирээд тасгийн захирагч болж дэвшсэн.


Өөрөө алба хаангаа үеийн нөхдөө удирдах нь хүндтэй бөгөөд тун хариуцлагатай ажил юм. “Монгол цэргийн өдөр”-өөр дэд түрүүч цол хүртэж, саяхан болж өнгөрсөн ЗХЖШ-ын цогцолбор шалгалтаар тактикийн хээрийн сургуульд тасгийн захирагчийн үүрэгтэйгээр оролцож, “Онц сурлагатан” цол, тэмдгээр бас шагнагдсан аав нь. Цэргийн албандаа дурлаад л, зүтгээд л байвал

үр, өгөөж, хайр энэрэл нь хязгааргүй юм. Аав нь энэ бүхнийг хүүдээ бичиж байгаа нь сургуульд орж, бичиг үсэг сураад, захидлыг маань уншаасай, цэргийн албаар бахархаасай, хожим 18 нас хүрээд энэ замналаар яваасай гэсэндээ тэмдэглэл болгон сийрүүлж байна. Бага балчраасаа эх орондоо хайртай, байгаль орчноо хамгаалдаг, зөвтөлөвшилтэй сайн хүү болоорой гэж аав нь хүснэ. Алаг нүдэн

үр минь аав нь удахгүй халагдана. Халагдаад сайхан хүүгээ цэцэрлэгт нь хүргэж өгч, үргэлж хамт байх болно оо. Тэр болтол хайртай эмээгийнхээ үгэнд сайн орж, цэцэрлэгтээ явж байгаарай. Аав нь үрдээ маш их хайртай шүү” хэмээн бяцхан хүүдээ цэргийн албаар бахархаж буйгаа сийрүүлэн ирүүлсэн байлаа.

АХЛАХ ДЭСЛЭГЧ  
Д.БОЛОР

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 084 ДҮГЭЭР АНГИЙН ШҮХЭРЧИН ДАЙЧИД ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН 60 КМ-ИЙН ЯВГАН МАРШИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Ангийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх дадлага, чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр тэвчээрийг дээшлүүлэх, рот, салааны захирагч, бүлгийн дарга

нарын удирдах арга барил, ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой 2021-2022 оны “Цэргийн сургалтын төлөвлөгөө”-ний дагуу тактик, тусгай бэлтгэлийн 60 км-ийн явган маршийг

8 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Маршийн хөдөлгөөн үйлдэх цэгүүдийг цэргийн байр зүй, тактик, инженерийн бэлтгэл, Үй олноор хөнөөх

зэвсгээс хамгаалах бэлтгэл, амьд гарах арга ухаан, хүн эмнэлэг гэсэн 6 цэгээр төлөвлөн явуулсан бөгөөд маршийн явцад сургуулийн удирдагч, дундын хянагч нар бие бүрэлдэхүүний

хөдөлгөөний байдалд байнгын хяналт тавьж ажиллажээ. Салбарууд дураалын дагуу тусгай хүчний сургалтын төв дээр ирмэгц 14,30 цагаас 17.00 хүртэл

7.62 мм АКМС, 9мм ПМ-ын бэлтгэл хурдан буудлагын дасгалуудыг боловсруулж гүйцэтгээд 17.20 цагт маршрутын дагуу хөдөлгөөн үйлдэж 20.40 цагт барианд орсон юм.